

IX. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТАЛААР

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн зарчмын дагуу 2003 оноос хойш төрийн удирдлага босоо тогтолцоотой хэрэгжиж ирсэн билээ. Ингэснээр салбар, байгууллага болон орон нутгийн төсвийг хариуцсан төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрийн төсөвт багтаан бүтээгдэхүүн нийлүүлж тайлагнадаг болсон. Орон нутгийн засаг захиргааны нэгж нь тухайн бүс, орон нутагт ойрхон ажиллаж, эцсийн хэрэглэгчид болох тухайн орон нутгийн ард иргэдийн өмнө ажлын үр дүн нь илэрхий байдаг тул орон нутгийн нэгжийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх нь тухайн бүс, орон нутгийн хөгжилд эергээр нөлөөлөх юм.

Төв, орон нутгийн засаглал хоорондын төсвийн харилцааг боловсронгуй болгох, орон нутгийн төсвийн эрхийг нэмэгдүүлэх үүднээс Монгол Улсын Татварын ерөнхий /шинэчилсэн/ хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар улсын төсвийн орлогод төвлөрдөг байсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татварыг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх болсон билээ.

Үүнтэй холбогдуулан орон нутгийн төсвийн орлого 2009 онд 97.5 тэрбум төгрөгөөр, үүнээс нийслэлийн орлого 62.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Ингэснээр 2008 онд нийт 16 аймаг улсын төсвөөс дэмжлэг авч байсан бол 2009 онд 11 аймаг улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авч, нийслэл болон 10 аймаг бие даан орон нутгийн төсвөө бүрдүүлэх нөхцөл бүрдэж байгаа юм.

Орон нутгийн төсвийн урсгал зардлын хэмжээ 2009 онд 116.2 тэрбум төгрөгт хүрч, 2008 оны аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төлөвлөгөөнөөс 21.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр төсвийн төсөлд тусгагдсан.

Аймаг, нийслэлийн орон нутгийн төсөвт Монголын хүүхдийн ордон, Хүүхдийн урлан бүтээх төв, Ус сувгийн газар, Улаанбаатар хотын архивын алба зэрэг улсын төсвөөс санхүүжиж байсан байгууллагыг шилжүүлснээр орон нутгийн төсвийн урсгал зардал 1054.8 сая төгрөгөөр, Засгийн газрын 2007 оны 318 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Хот байгуулалт, барилга захиалагчийн албыг орлогоороо зарлагаа нөхөх зарчмаар ажиллуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан 1068.5 сая төгрөгөөр, мөн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарагддаг орон нутгийн хэрэгжүүлэгч агентлаг Иргэний бүртгэлийн албыг төрийн сангийн тогтолцоонд шилжүүлэн улсын төсвийн нэгтгэлд хамруулахаар тооцсонтой холбогдон 1761.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж байна.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 8.3.4 дэх заалтыг үндэслэн Дархан-Уул аймгийн Шарын гол, Хонгор, Дархан суманд байгуулсан ахмад, настны кабинет, төвийн урсгал зардалд 61.1 сая төгрөгийг шинээр нэмж тусгасан.

“Хүн ам, орон сууцны тооллогын тухай хууль”-ийн дагуу хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг 2010 оны 1 сард зохион байгуулахаар УИХ-аас товыг тогтоосон. Үүнтэй холбогдуулан тооллогыг зохион байгуулж явуулахтай холбогдон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх зардлыг 1.3 тэрбум төгрөгөөр тооцон орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийн 2009 төсвийн төсөлд тусгалаа. Уг зардалд өрх, хүн амын урьдчилсан бүртгэл гаргах зардал, сум, аймгийн тооллогын түр товчооны үйл ажиллагааны болон сургалтын зардал, тоологч, шалгагч нарын сургалт семинарын зардлыг тооцсон. Харин тоологч, шалгагч нарын цалин, хоолны зардал, тооллогын материал хүргэх зардал 1.8 тэрбум төгрөгийг 2010 оны төсвийн төсөлд тусгахаар тооцлоо.

“Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай” Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоолоор Монгол

Улсын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн албаны бүтцийг төрийн сангийн тогтолцоонд шилжүүлж, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын төрийн сангийн хэлтэс, сумын төрийн сангийн төлөөлөгч гэсэн бүтцээр ажиллуулахаар заасны дагуу 6 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Тухайн үеийн төсөв санхүүгийн боломж, ажлын ачааллыг харгалзан Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 323 дугаар тушаалаар Сумын Засаг даргын орлогч нь сумын төрийн сангийн төлөөлөгч байхаар зохион байгуулан ажиллаж ирсэн. Гэтэл сүүлийн жилүүдэд Засгийн газрын удирдлага, мэдээллийн цахим сүлжээг сумдад нэвтрүүлж, уг сүлжээгээр сумын төсөвт байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх, орон нутгийн төсвийн төслийг нэгтгэх, батлагдсан төсвийг хуваарилах, санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэх зэрэг ажлууд хийгдэх болж ажлын ачаалал нэмэгдэж байгаа тул мэргэжлийн, мэргэшсэн төрийн захиргааны албан хаагч уг ажлыг гүйцэтгэх зайлшгүй шаардлага гарч ирсэн. Үүнтэй холбогдуулан “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2008 оны 26 дугаар тогтоолоор Засгийн газрын удирдлага мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон сумын Засаг даргын Тамгын газарт төрийн сангийн мэргэжилтэн ажиллуулахыг Сумын Засаг дарга нарт зөвшөөрсөн байна. Нөгөө талаас 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн “Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-иар Сумын Засаг даргын орлогч нь улс төрийн албан тушаалтан байхаар хуульчилан батлагдсан тул сумын төрийн сангийн төлөөлөгч гэсэн төрийн захиргааны албан тушаалыг давхар гүйцэтгэх нь эрх зүйн хувьд боломжгүй болсон.

Иймд Засгийн газрын удирдлага, мэдээллийн системд холбогдсон сумдад ажиллах төрийн сангийн төлөөлөгчийн урсгал зардлыг 896.9 сая төгрөгөөр тооцон Сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн төсөлд тусгасан.

Улс, орон төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутгийн иргэний бүртгэлийн ажилтан, халамжийн байцаагч, газрын даамлыг сум бүрт 1 орон тоо, эд хөрөнгийн бүртгэлийн байцаагч сум бүрт 2 орон тоо, нийт 1593 орон тоог шинээр нэмэгдүүлэх санал ирүүлсэн.

Эдгээр орон тооны ажлын чиг үүрийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулахаар тооцон 2009 оны төсвийн төсөлд дараах байдлаар тусгалаа. Үүнд:

Нийгмийн халамжийн тэтгэмжийн хэмжээ ихээхэн нэмэгдэж, нэг суманд 6.0-9.0 тэрбум төгрөг хуваарилагдаж байгаа тул төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах зорилгоор нийгмийн ажилтаны орон тоогүй сум, хороодод нийгмийн ажилтан буюу халамжийн байцаагчийн орон тоог бий болгохоор тооцож, аймаг, нийслэлийн халамж, үйлчилгээний хэлтсийн орон тоог 273 хүнээр нэмэгдүүлж, эдгээр ажилтны зардалд 1137.3 сая төгрөгийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын төсвийн багцад шинээр тусгасан.

Уг халамжийн байцаагчийн чиг үүргийг сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн ажилтан давхар гүйцэтгэж байсан бөгөөд халамжийн байцаагчийн орон тоо нэмэгдсэнээр сумын нийгмийн ажилтаны ажлын ачаалал багасах юм. Иймд сумын Тамгын газрын нийгмийн ажилтанд иргэний бүртгэлийн ажлыг давхар хариуцуулахаар тооцон иргэний бүртгэлийн ажилтаны орон тоог шинээр нэмж тусгаагүй болно.

Зам, тээвэр, барилга хот байгуулалтын төсвийн ерөнхийлөн захирагчаас орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа 255 газрын даамлын орон тоог улсын төсөвт шилжүүлэх санал ирүүлсэн.

Газрын даамлын ажлын чиг үүрэгт эд хөрөнгийн байцаагчийн чиг үүргийг давхар хариуцуулах боломжтой гэж үзэн одоо ажиллаж байгаа сумын газрын даамлын орон тоогоор тооцож, сумын Засаг даргын Тамгын газрын төсөвт тусгасан.

Орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийг дараах зориулалтаар шинэчлэн тусгалаа. Тухайлбал, байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах, гоц халдварт өвчний голомтыг арилгах, тархалтыг хязгаарлах,

шагнал, урамшуулал, буцалтгүй тусламж, баяр, наадам, уналга, цугларалт, бэлтгэл сургуулилт, мал болон хүн амын тооллого, болзошгүй зардлын нөөц гэсэн зориулалтаар тус тус тооцсон. Ингэснээр орон нутгийн нөөц хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт ил тод болж, байгалийн гамшиг болон гоц халдварт өвчний голомтыг арилгах, тархалтыг хязгаарлах асуудалд улсын төсвөөс нэмэлт хөрөнгө гаргах, эсэх асуудал тодорхой болох юм.

Орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийг зориулалтаар харуулбал:
(сая төг-өөр)

	2009 төсөл
НИЙТ ДҮН	5,860.3
Байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах	1,656.4
Гоц халдварт өвчний голомтыг арилгах, тархалтыг хязгаарлах	686.5
Шагнал, урамшуулал, буцалтгүй тусламж тэтгэмж	510.1
Баяр, наадмын зардал	605.3
Уналга, цугларалт, бэлтгэл сургуулилт	181.4
Мал тооллого	126.2
Хүн амын тооллого	1,352.7
Болзошгүй зардлын нөөц	741.7

Төрийн албаны хуулийн дагуу тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд 1963.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт шинээр нэмж тусгасан.

Хотын нийтийн тээврийн татааст зориулан 14684.1 сая төгрөгийг нийслэлийн төсөвт тусгасан нь 2008 оны батлагдсан төсвөөс 7306.2 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Нийслэлийн Налайх дүүргийн Городок, Багахангай дүүргийн дулааны цахилгаан станцын дулааны алдагдлын татаас 2009 оны төсвийн төслөөр 212.0 сая төгрөг болж 2008 оны батлагдсан төсвөөс 62.0 сая төгрөгөөр нэмэгдэхээр тооцогдож байна. Налайх, Багахангай дүүргүүдийн иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагад борлуулах дулааны үнийг нэмэгдүүлэхгүй байгаатай холбоотойгоор үйл ажиллагааны алдагдал үүсч байгаа тул Багахангай дүүргийн дулааны станцын алдагдалд 122.9 сая төгрөг, Налайх дүүргийн Городокийн дулааны алдагдалд 89.1 сая төгрөгийг тус тус тусгалаа.

Орон нутгийн хот тохижуулах байгуулагуудын үйл ажиллагааг хот орчныг тохижуулах, нийтийн эзэмшлийн гудамж талбайг цэвэрлэх, айл өрхийн хогийг зөөх, хотын гэрэлтүүлгийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөрөөр төлөвлөж, 2008 оноос 4,1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлээ.

Ийнхүү хот орчныг тохижуулах талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагын үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийслэлд хот тохижуулах үйл ажиллагааны зардлыг 2,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь хот тохижуулах байгуулагуудын тогтмол зардлын өсөлт болон нийт зардлын өсөлтийн 50 гаруй хувийг эзэлж байна.